<i>Зээлийн хүүгийн авлага</i>	6.0	4.0	-2.0
Эрүүл мэндийн төв /Эрүүл мэндийн даатгалын сан/	0.4	78.7	78.3

Эх сурвалж: Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлсэн татаас санхүүжилтийн авлага 4.4 сая төгрөг, Цар тахлын үед үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний ЭМДС-аас авах 78.7 сая төгрөгийн авлага үүссэн байна.

### Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат зээл, хувь хүмүүс олгосон зээл дансны эхний үлдэгдэл 55.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 54.4 сая төгрөг болж өмнөх оноос 0.8 сая төгрөгөөр буурсан байна. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 21.1 сая төгрөг байгаа нь анхаарал татаж байна.

### 3.5.5 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 425.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 490.5 сая төгрөг болж 65.5 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засаг даргын Тамгын газар	39.6	45.6	6.0
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.7	0.7	0.0
Соёлын төв	10.2	11.3	1.1
Ерөнхий боловсролын сургууль	196.7	170.2	-26.5
Бүрэнхаан бага сургууль	47.0	58.7	11.7
Хүүхдийн цэцэрлэг	48.8	64.4	15.6
Эрүүл мэндийн төв	81.9	139.6	57.7
<b>Нийт дүн</b>	<b>425.0</b>	<b>490.5</b>	<b>65.5</b>

Эх сурвалж: Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны материаллаг өөрчлөлтөд ерөнхий боловсролын сургуулийн бараа материалын данс 26.6 сая төгрөгөөр буурсан, хүүхдийн цэцэрлэг, Бүрэн хаан бага сургуулийн бараа материал данс 11.7 сая төгрөгөөр, эрүүл мэндийн төвийн бараа материалын данс 57.7 сая төгрөгөөр, ЗДТГ-ын бараа материал данс 6.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж нөлөөлсөн байна.

## Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,386.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7,219.9 сая төгрөг болж 833.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт/-
Бүрэнхаан бага сургууль	226.5	733.3	506.8
Засаг даргын тамгын газар	1,130.6	1,125.6	(5.0)
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.0	7.5	7.5
Соёлын төв	941.9	910.6	(31.3)
Сургууль	2,240.0	2,572.0	331.9
Хүн эмнэлэг	1,603.7	1,590.2	(13.5)
Цэцэрлэг	243.7	280.7	37.0
<b>Нийт</b>	<b>6,386.4</b>	<b>7,219.9</b>	<b>833.5</b>

Эх сурвалж: Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө олж бэлтгэсэн байдлыг авч үзвэл: Худалдан авсан 135.4 сая төгрөг, хандиваар 23.5 сая төгрөг, шилжүүлсэн авсан 31.8 сая төгрөг, төсвийн хөрөнгө оруулалтаар 680.2 сая төгрөг, дахин үнэлсэн 19.4 сая төгрөг байна.

Хөрөнгийн зарлага болгосон байдлыг авч үзвэл: Тайлант онд байгуулсан элэгдлийн зардал 417.1 сая төгрөг, өмнөх онд хамаарах элэгдэл 348.8 сая төгрөг /тооцооллын зөрүү/байна.

АИТХ-ын тогтоолоор нийт 130.8 сая төгрөгийг 0 үлдэгдэлтэй хөрөнгийг данснаас хасаж ашиглах боломжтой хөрөнгийг үнэлэн 33.0 сая төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байна.

## Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийн эхний үлдэгдэл 237.4 сая төгрөг эцсийн үлдэгдэл 225.0 сая төгрөг байна. Тайлант онд ашиглалтгүй байгаа 16.6 сая төгрөгийн программ хангамж данснаас хассан, тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал 5.4 сая төгрөг байна.

## 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 181.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 166.8 сая төгрөг болж 14.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Бүрэнхаан бага сургууль	0.0	3.1	3.1
Засаг даргын тамгын газар	66.9	49.4	-17.5
Соёлын төв	114.4	114.4	0.0
<b>Нийт дүн</b>	<b>181.3</b>	<b>166.8</b>	<b>-14.5</b>

Эх сурвалж: Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эцсийн өр төлбөрийн 0.8 сая төгрөг ажилчидтай холбоотой НДШ-ийн өглөг, байгууллагад төлөх төлбөр 166.0 сая төгрөг байна. Байгууллагад төлөх төлбөр нь халаалтын тооцооны он дамжсан өглөг байна.

## 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо данс

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,985.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8,069.4 сая төгрөг болж 1,084.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,175.0	2,175.0	0.0

Хуримтлагдсан үр дүн	3,141.4	4,258.0	1,116.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,668.6	1,636.5	-32.1
<b>Нийт дүн</b>	<b>6,985.0</b>	<b>8,069.4</b>	<b>1,084.4</b>

Эх сурвалж: Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн 735.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгө данснаас хассаны зөрүү 32.1 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5.10 Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлогыг 4,755.2 сая төгрөгөөр тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 182.2 сая төгрөг буюу 4.0 хувиар өссөн байна. *Хүснэгт №7 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого*

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	142.1	252.6	110.5	77.8
Татварын бус орлого	153.8	1,078.4	924.6	601.0
Тусламж санхүүжилтийн орлого	4,277.1	3,424.2	-852.9	-19.9
<b>Нийт дүн</b>	<b>4,573.0</b>	<b>4,755.2</b>	<b>182.2</b>	<b>4.0</b>

Тайлант хугацааны орлогыг өмнөх үетэй зэрэгцүүлбэл: Татварын бус орлого 924.6 сая төгрөгөөр өссөн, тусламж санхүүжилтийн орлого 852.9 сая төгрөгөөр буурсан байна.

Эрүүл мэндийн төвд корона вирус цар тахалтай холбоотой үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого, Бүрэнхаан бага сургуульд сургуулийн байр шинээр баригдаж хүлээн авсан орлого тус тус нөлөөлсөн байна.

### 3.5.11 Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар тайлант онд нийт 4,019.6 сая төгрөгийн зардал гаргасан байна.

*Хүснэгт №8: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал*

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардал	4,569.5	3,853.4	716.1	-15.7
Үйл ажиллагааны бус зардал	87.2	166.1	79.0	90.6
<b>Нийт дүн</b>	<b>4,656.7</b>	<b>4,019.6</b>	<b>-637.1</b>	<b>-13.7</b>

Эх сурвалж: Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант 2021 онд өмнөх оноос 637.1 сая төгрөгийн бага зардал гаргаж ажилласан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” –ын хэрэгжилтийг хэрэгжилтийг хянан үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

- Сумын ЗДТГ - оффисын тавилга, нормын хувцас худалдан авахад 3.5 сая төгрөг зарцуулсан
- Сумын ИТХ - Тайлант хугацаанд уралдаан тэмцээний шагналд 0.4 сая төгрөг зарцуулсан

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Бүрэнтогтох сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар ТЭЗ-ийн өргөн мэдүүлсэн 2021 оны төсвийн төслийг хэлэлцэн 02

дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 13 хөтөлбөрт зориулан 3,228.6 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Бүрэнтогтох сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 42 дугаар тогтоолоор 2021 оны төсөвт тодотгол хийж 55.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 3,383.6 сая төгрөгөөр баталсан байна.

Нийт 3,567.6 сая төгрөгийн зардлын 2,140.1 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 107.5 сая төгрөгийг ОНХНС-аас, 1,082.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 44.7 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 91.5 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлтөөс, 2.4 сая төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос, урьд оны үлдэгдлээс 98.9 сая төгрөгөөр төгрөг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

#### Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Бүрэнтогтох сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 2020 оны 10 дугаар сарын 31-ий өдрийн 09 дугаар тогтоолд зааснаар Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 168.8 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 266.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 157.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Үйл ажиллагааны орлого	2.0	12.1	4.5	10.1
Хөрөнгийн орлого	19.0	26.9	10.1	7.9
Шууд бус орлого	21.5	26.8	10.1	5.3
Хөрөнгө борлуулсны орлого	0.0	7.6	2.9	7.6
Бууны албан татвар	4.2	4.6	1.7	0.4
Малд ногдуулах албан татвар	55.0	93.7	35.2	38.7
Улсын тэмдэгтийн хураамж	4.3	7.4	2.8	3.1
Түгээмэл тархацтай АМАТ	4.8	9.0	3.4	4.2
Газрын төлбөр	2.7	7.8	2.9	5.1
Дуудлага худалдаа	5.0	2.3	0.9	-2.7
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.0	0.1	0.0	0.1
Ойн нөөц ашигласны төлбөр	39.1	53.4	20.0	14.3
Байгалын ургамлын нөөц ашигласны төлбөр	0.1	0.0	0.0	-0.1
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.6	0.8	0.3	0.2
<b>Татварын орлогын дүн</b>	<b>158.3</b>	<b>252.5</b>	<b>94.7</b>	<b>94.2</b>
Торгуулийн орлого	8.0	12.5	4.7	4.5
Түрээсийн орлого	2.5	1.5	0.6	-1.0
<b>Татварын бус орлогын дүн</b>	<b>10.5</b>	<b>14.0</b>	<b>5.3</b>	<b>3.5</b>
<b>Нийт орлогын дүн</b>	<b>168.8</b>	<b>266.5</b>	<b>100.0</b>	<b>97.7</b>

Эх сурвалж: Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Сумын орон нутгийн орлого 97.7 сая төгрөгөөр давсан нь үйл ажиллагааны орлого, малд ногдуулах албан татварын орлогын төлөвлөгөө давж биелснээс шалтгаалсан байна.

Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 0.1 сая төгрөгөөр, түрээсийн орлого 1.0 сая төгрөгөөр, дуудлага худалдааны орлогын төлөвлөгөө 2.7 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

**Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:** Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 149.4 сая төгрөгөөр төлөвлөж 177.4 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 18.8 сая төгрөг буюу 28.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

**Хүснэгт №10: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл**

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	124.5	139.8	15.34
2	Үл хөдлөх хөрөнгийн татвар	2.2	2.3	0.1
3	Газрын төлбөр	4.1	11.1	7.06
4	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	15.0	18.7	3.58
5	Зам ашигласны төлбөр	3.3	5.2	1.94
6	Түрээсийн орлого	0.3	0.3	0
6	<b>Нийт дүн</b>	<b>149.4</b>	<b>177,4</b>	<b>18.8</b>

Эх сурвалж: Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

**Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:** Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 4.07 сая төгрөгөөр төлөвлөж 6.09 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 2.02 сая төгрөг буюу 49.38 хувиар давуулан биелүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

**Хүснэгт №11: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл**

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1.52	1.59	0.07
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	0.71	0.82	0.11
3	Агаарын бохирдлын төлбөр	1.84	3.68	1.84
4	<b>Нийт дүн</b>	<b>4.07</b>	<b>6.09</b>	<b>2.02</b>

Эх сурвалж: Бүрэнтогтох сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

**Тусламж санхүүжилтийн орлогын талаар**

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 3,161.3 сая төгрөгөөр төлөвлөж, 3,080.8 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 98.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 13 хөтөлбөрт зориулан 3,567.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3,278.7 сая төгрөгийг урсгал зардалд, 198.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 90.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Төсвийн хуваарийн дагуу аймгаас авах санхүүгийн дэмжлэг 913.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг бүрэн санхүүжиж, тусгай зориулалтын шилжүүлэг 2,059.6 сая төгрөгийн санхүүжилт авч 92.8 хувийн гүйцэтгэлтэй, ОНХС-ын шилжүүлгээр 107.5 сая төгрөг авахаас бүрэн санхүүжиж харьяа байгууллага, тусгай сангуудад санхүүжилтийг бүрэн олгож ажилласан байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 91.5 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөж гүйцэтгэлээр 89.5 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлт төлөгдсөн байна.

**Төсвийн зарлагын талаар:**

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,292.1 сая төгрөг буюу 92.3 хувьтай байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” хэрэгжсэнтэй холбоотой зарим зардлыг хэмнэн ажилласантай холбоотой байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 25.7 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 3.2 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 3.3 сая төгрөг
- Хангамж, бараа материалын зардал 8.1 сая төгрөг
- Нормативт зардал 35.8 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 5.7 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 6.8 сая төгрөг
- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал 9.6 сая төгрөг
- Хөрөнгийн зардал 83.2 сая төгрөг

Сум хөгжүүлэх сангаас 90.0 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн боловч зээлийн олголт хийгээгүй байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 23.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 72.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 11 төсөл, арга хэмжээнд 118.7 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 93.5 сая төгрөгийн санхүүжилт олгож орон нутгийн хөгжлийн сангийн дансны үлдэгдэл 26.5 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 14.6 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 16.8 сая төгрөг, засаг даргын нөөц хөрөнгөнөөс 7.6 сая төгрөг, ЭМЯ, ЭМГазраас ковид 19 цар тахалтай тэмцэх үйл ажиллагааны дэмжлэгт 107.3 сая төгрөг нийт 146.3 сая төгрөгийг орлогыг бүрдүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд: Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, орон нутагт малын гоц халдварт өвчинтэй тэмцэх гэх мэт үйл ажиллагаа нь онцлог асуудал байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг заасан хугацаанд байршуулаагүй, төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмээг хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан зарим мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн

Сумын ИТХ-ын дарга Эсмэдэх нь 2021 онд сумын ИТХ-ын төсвийн шууд захирагчийн албан үүргийг гүйцэтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 14.1.15. “аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн; ерөнхийлөн захирагч байна, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. “Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно” заалттай нийцэхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, 146 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл /бүтэн жилээр/
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан

Аудитын түүвэр хамрагдсан байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянан үзэхэд:

1. Бүрэн хаан бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор – 5 мэдээлэл хугацаа хоцроосон
2. Соёлын төв – 4 мэдээлэл хугацаа хоцроосон
3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал – 3 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлж мэдээллийг тухай бүр мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сангийн яамны төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэх системд байгууллагын нэрийг үнэн зөв мэдээлээгүй, байгууллагын гэрчилгээний нэр, улсын бүртгэл дэх нэр, дүрмийн сангийн дүн зөрүүтэй байна. Тухайлбал: “Эрүүл мэндийн төв”-ийг “хүн эмнэлэг” гэсэн байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Сангийн яамны төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн системд байгууллагын нэрийг бүрэн үнэн зөв оруулах, улсын бүртгэлийн гэрчилгээнд байгууллагын нэр, дүрмийн сангийн дүнг өөрчилж бүртгүүлэх гэсэн зөвлөмж өгч байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмж биелэлтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлж 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2022 оны төсвийн талаар баримтлах бодлогын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, 2018 онд нэгдсэн халаалтын зуухтай болсонтой холбоотой ЗДТГ 49.4 сая төгрөг, сумын соёлын төв 114.4 сая төгрөгийн халаалтын тооцооны өглөгтэй байна. Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар дээрх өглөгийг төлж барагдуулах, цаашид нэмэгдүүлэхгүй байх, сумын төсвийн орлогоос өглөг барагдуулах талаар сумын холбогдох албан тушаалтнууд арга хэмжээ авч ажилласан эсэхийг анхаарч үзэх нь зүйтэй.

## 4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 7 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлан, 9 төсвийн гүйцэтгэлийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

№	Байгууллагын нэр	Аудитад хамрагдсан байдал	Аудитын дүгнэлт
1	Засаг даргын Тамгын газар	Дүгнэлт гарсан	Зөрчилгүй
2	Ерөнхий боловсролын сургууль	Дүгнэлт гарсан	Зөрчилгүй
3	Хүүхдийн цэцэрлэг	Дүгнэлт гарсан	Зөрчилгүй
4	Эрүүл мэндийн төв	Дүгнэлт гарсан	Зөрчилгүй
5	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	Түүвэрт хамрагдсан	
6	Бүрэн хаан бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор	Түүвэрт хамрагдсан	
7	Соёлын төв	Түүвэрт хамрагдсан	
8	Сум хөгжүүлэх сан	Түүвэрт хамрагдсан	
9	Орон нутгийн хөгжлийн сан	Түүвэрт хамрагдсан	

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 334.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.3 сая төгрөгийн алдааг залруулж, 329.8 сая төгрөгийн алдаа зөрчилд 14 зөвлөмж өгсөн.

#### 4.1 Залруулсан алдаа

Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 4.3 сая төгрөгийн нягтлан болох бүртгэлтэй холбоотой алдаа залруулсан байна.

#### 4.2 Төлбөрийн акт

**Төлбөрийн акт тогтоогоогүй болно**

#### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй байна.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Сум хөгжүүлэх сантай холбоотой асуудал

**1.1 Илрүүлэлт:** Сум хөгжүүлэх сангаас 90.0 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн боловч зээл олгоогүй байна. Зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн 21.1 сая төгрөгийн зээл байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.2.2. “Сум хөгжүүлэх болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх” заалттай нийцэхгүй эрх ба үүрэг батламж мэдэгдлийг байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Тайланд батлагдсан хэмжээгээр зээлийн олголт хийж төсвийн гүйцэтгэл ханган ажиллах, хугацаа хэтэрсэн 21.1 сая төгрөгийн зээлийг төлүүлэх талаар бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

##### 2. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал:

**2.1 Илрүүлэлт:** Тайлант хугацаанд НДШ-ийн тооцоотой холбоотой 7.8 сая төгрөгийн авлага, 0.8 сая төгрөгийн өр төлбөр үүссэн, халаалтын зардалтай холбоотой 166.0 сая төгрөгийн өглөг байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2.”өр, авлага үүсгэхгүй байх” заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Төсвийг зохистой удирдаж өр, авлага үүсгэхгүй байх, өглөг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

##### 3. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой асуудал:

**Илрүүлэлт:** Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 0.1 сая төгрөгөөр, түрээсийн орлого 1.0 сая төгрөгөөр, дуудлага худалдааны орлогын төлөвлөгөө 2.7 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн биелүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байх.

#### 4. ТӨСВИЙН ХЭМНЭЛТИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.1 Илрүүлэлт: Тайлант онд ЗДТГ 2.5 сая төгрөгөөр оффисын тавилга, 1.0 сая төгрөгөөр нормын хувцас, ИТХ 0.4 сая төгрөгийг тус тус тэмцээн, уралдаан зохион байгуулахад зарцуулсан Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4, 1.6 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Засгийн газар болон бусад эрх бүрий байгууллагаас тухайн жилийн төсөвтэй холбоотой гаргасан тогтоол, тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах

#### 5. ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ГАРСАН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

5.1 Илрүүлэлт: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 47.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

5.2 Өгсөн зөвлөмж: Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмжийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн тул хэрэгжилтэд анхаарч ажиллан, зөвлөмжийн биелэлтийг нэгтгэн ирүүлэх

#### 6. ТӨСӨВ ЗАХИРАГЧТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

6.1 Илрүүлэлт: ИТХ-ын дарга М.Эсмэдэх нь сумын ИТХ-ын төсвийн шууд захирагчийн албан үүргийг гүйцэтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 14.1.15. “аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн; ерөнхийлөн захирагч байна”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. “Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно” заалттай нийцэхгүй байна.

6.2 Өгсөн зөвлөмж: ИТХ-ын дарга нь Төсвийн тухай хуульд заасан төсвийн захирагчийн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
			Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>										
Бүрэнтогтох сумын ТТЗ	1	4.7							1	4.7
Харьяа байгууллагуудын зөрчил										
Бүрэнтогтох сумын ИТХ	3	62.9							3	62.9
Бүрэнтогтох сумын ЗДТГ	2	52.7							3	52.7
Эрүүл мэндийн төв	1	4.3	1	4.3						
Бүрэнтогтох сумын Хүүхдийн цэцэрлэг	1	0.0							1	0.0
Бүрэнтогтох сумын сум хөгжүүлэх сан	1	111.1							1	111.1
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>235.7</b>	<b>1</b>	<b>4.3</b>					<b>8</b>	<b>231.4</b>
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>										
Бүрэнтогтох сумын ТТЗ	1	0.0							1	0.0
Харьяа байгууллагуудын зөрчил										
Бүрэнтогтох сумын ЗДТГ	1	54.5							1	54.5



Бүрэнтогтох сумын Эрүүл мэндийн төв	1	0.0						1	0.0
Бүрэнтогтох сумын Ерөнхий боловсролын сургууль	1	43.9						1	43.9
Бүрэнтогтох сумын Хүүхдийн цэцэрлэг	1							1	
Бүрэнтогтох сумын ИТХ	1							1	
Бүрэнтогтох сумын Соёлын төв	1							0	
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>98.4</b>						<b>6</b>	<b>98.4</b>
<b>Нийт дүн</b>	<b>15</b>	<b>334.1</b>	<b>1</b>	<b>4.3</b>				<b>14</b>	<b>329.8</b>